

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### “ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

#### АУДИТЫН КОД:ХОА-2021/15-20/ШТА-ГА

Ховд хот	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn
2021 он	Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:99013699 Цахим хаяг:tsetsegsuren.a@audit.gov.mn
	Ахлах аудитор: Л.Галбадрах Утас: 40432545 Цахим хаяг: galbadrakgl@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Мөнхтулга Утас: 70432545 Цахим хаяг: munkhtulga.d@audit.gov.mn
	Аудитор: Ц.Аззаяа Утас:7043-2545 Цахим хаяг: <a href="mailto:azzavats@audit.gov.mn">azzavats@audit.gov.mn</a>

## АГУУЛГА

<b>Товчилсон үгийн тайлбар</b> .....	4
<b>Хүснэгт, графикийн товъёог</b> .....	4
<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b> .....	4-5

### **БҮЛЭГ 1. Дотоод аудитыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин оновчтой бүрдээгүй, Санхүүгийн хяналт, аудитын алба нь Төрийн албаны тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт зарлаагүй, үйл ажиллагааг хараат бусаар явуулаагүй байна.** ....6

1.1 Төсвийн тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хуулиар санхүүгийн хяналт, шалгалтыг хуульчилж өгсөн ч дотоод аудитыг хэрхэн явуулах эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байна.....7

1.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан дотоод аудитын дүрэм нь мэргэжлийн практикийн олон улсын стандарт, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, шийдвэрүүдтэй уялдаагүй, шинэчлэн батлуулаагүй байна.....8

1.3 Төсвийн ерөнхийлөн захирагчаас дотоод аудитыг хэрэгжүүлэх орон тоо, төсвийг баталсан ч Төрийн албаны тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй, дотоод аудиторт тавигдах шалгуур, ажлын байрны шалгуурыг хангахгүй албан хаагчдыг томилон ажиллуулж байна. ....9

1.4 Санхүүгийн хяналт, аудитын алба нь чиг үүргээ хөндлөнгийн нөлөөлөлгүй, хараат бусаар хэрэгжүүлж чадахгүй байна.....11

1.5 Санхүүгийн хяналт, аудитын албаны санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн, чиг үүрэгт тусгасан дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй байна....13

### **БҮЛЭГ 2. Төсвийн тухай хуульд заасан ТЕЗ-ийн дотоод аудитын чиг үүрэг үр нөлөөтэй хэрэгжихгүй байна.** ....13

2.1 Санхүүгийн хяналт, аудитын алба нь дотоод аудитын дүрэм, стандартын дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулаагүй байна.....13

2.2 Санхүүгийн хяналт аудитын алба дотоод аудитын чиг үүргээ хэрэгжүүлээгүй, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.....14

2.3 Дотоод аудитын нэгж үйл ажиллагаагаа хараат бусаар удирдах, хэрэгжүүлэх, хянах, тайлагнах нөхцөл бүрэн бүрдээгүй байна.....15

2.4 Санхүүгийн хяналт, аудитын алба нь санхүүгийн хяналт, шалгалтын тайланг цахим сайтад байршуулахаар бие даасан сайттай болсон ч мэдээллийг ил тодоор иж бүрэн мэдээлээгүй байна.....16

2.5 Санхүүгийн хяналт, аудитын алба нь дотоод аудитын дүрэмдээ заасан хөндлөнгийн аудитын байгууллагуудтай хамтран ажиллах заалтын хэрэгжилт хангагдаж байна.....17

2.6 Чанарын үнэлгээгээр өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, стандартад заасан чанарын баталгаажуулалт ба сайжруулалтын хөтөлбөрийг баталж үйл ажиллагаандаа мөрдөөгүй байна. ....17

2.7 Санхүүгийн хяналт, аудитын алба нь зөрчлийг арилгуулах албан шаардлагын хэрэгжилтийн бүрэн хангуулаагүй, зөвлөмж өгсөн боловч Дотоод аудитын хороонд танилцуулж тогтоолоор баталгаажуулаагүй, зөвлөмжийг бүртгээгүйгээс байгууллагаас ирүүлсэн цаашид авах арга хэмжээний саналын хэрэгжилтийг үнэлж тайлан мэдээнд тусгаагүй байна.....18

2.8 Санхүүгийн хяналт, аудитын алба нь санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллахдаа төсөвт байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах талаар тодорхой ажил хийгээгүй байна.....19

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:.....19

ЗӨВЛӨМЖ:.....20

**АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ:**.....

**ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:** .....

**САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:**.....

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ДАМПОУС	Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СХС	Сум хөгжүүлэх сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ШТА	Шууд тайлагнах аудит
ГА	Гүйцэтгэлийн аудит
ХОА	Ховд аймаг дахь Төрийн аудитын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар

### Хүснэгт, Графикийн товьёг

Хүснэгт 1: СХАА-ны сүүлийн 3 жилийн батлагдсан төсөв гүйцэтгэл

График 1: Баруун 5 аймгийн батлагдсан орон тооны харьцуулалт

График 2: Илрүүлсэн зөрчил /2019-2021 оны 9 сараар/

График 3: Актын биелэлт /2019-2021/

<p><b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b></p>	<p><b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b></p> <p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/27 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийлээ.</p>
<p><b>Аудитын зорилт</b></p>	<p>Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтийн байдалд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулан аймгийн ИТХ, Засаг дарга, Дотоод аудитын хороо болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.</p> <p>Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>➢ Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо оновчтой эсэх;</li><li>➢ Төрийн байгууллагууд дотоод аудитын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх.</li></ul>
<p><b>Аудитын хамарсан хүрээ</b></p>	<p>Аудитад аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон байгууллагуудын дотоод аудитын үйл ажиллагааны мэдээлэл, тайлан, хяналт шалгалтын тайлан, санхүүгийн хяналт, аудитын албаны 2019-2021 онуудын үйл ажиллагааны тайлан, төсвийн хөрөнгийн зарцуулалтын анхан шатны баримт, байгууллагын тушаал шийдвэрүүд, дотоод аудитын хорооны хуралдааны тэмдэглэл, хурлаас гарсан шийдвэрүүд, бусад байгууллагаас хийсэн хяналт шалгалтын тайлан, тоон өгөгдөл болон бусад нотлох баримтад үндэслэн дүн шинжилгээ хийж аудитыг гүйцэтгэнэ.</p>
<p><b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b></p>	<p>Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 олон улсын стандарт, MNS6817:2020 үндэсний стандартуудыг үндэслэн Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудитын заавар аргачлалыг дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх аудитын арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p><b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</b></p> <p><b>Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:</b></p>	<p>Аудитыг Ховд аймгийн аудитын газрын дарга тэргүүлэх аудитор Х.Болдбаатар удирдан, аудитын менежер А.Цэцэгсүрэн явцын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Л.Галбадрах, Д.Мөнхтулга, аудитор Ц.Аззаяа нар 2021 оны 09-р сарын 15-наас 11-р сарын 01-ныг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.</p> <p>Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцооны талаар I бүлэгт, Төрийн байгууллагууд дотоод аудитын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж талаар II бүлэгт тус тус тайлагнаж албан шаардлага, зөвлөмж хүргүүлэв.</p>

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Дотоод Аудиторуудын Олон Улсын Институтээс 2017 онд бүрэн хэмжээний өөрчлөлт оруулсан Дотоод Аудитын Мэргэжлийн Практикийн Олон Улсын Стандарт (ДАМПОУС)-д “Дотоод аудит”-ыг “Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой баталгаа өгөх, зөвлөх үйл ажиллагаа, дотоод хяналтын үйл явцыг үнэлэн, хараат бус үнэлгээ өгөх зорилгоор зохих нотолгоонд үндэслэн хийж байгаа шалгалт” гэж тодорхойлжээ.

Төсвийн тухай хуульд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангаж, төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна гэж заасан байна.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-д төрийн байгууллагуудын дотоод аудитын албаны үйл ажиллагаанд бүх төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн засаг захиргааны дотоод аудитын алба, тэдгээрийн харьяа байгууллагын дотоод аудитын албадын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа хамаарахаар тусгагдсан байна.

Дотоод аудитын дүрэм нь дотоод аудитын нэгжийн зорилго, эрх ба үүргийг тодорхойлсон бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалт болон дотоод аудиторын эрх, үүргийг тодорхойлж, дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтран ажиллах харилцааг зохицуулж байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар “Санхүүгийн хяналт, шалгалтын стандарт”, 2019 оны 29 дүгээр тушаалаар “Дотоод аудитын хорооны дүрэм”, 2019 оны 268 дугаар тушаалаар “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, 2019 оны 274 дүгээр тушаалаар “Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам”, “Чанарын үнэлгээний аргачлал”-ыг тус тус баталсан байна.

Дээрх эрх зүйн баримт бичгүүдэд дотоод аудитын төлөвлөлт, дотоод аудитыг хэрхэн гүйцэтгэх, тайлагнах, зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн хянах үе шат бүрийг тусгаж өгснөөс гадна нийцэл, гүйцэтгэл, санхүүгийн аудит болон мэдээллийн технологийн засаглал, түүний эрсдэл, хяналтыг үнэлэх талаар арга зүй, аудитын явцад ашиглах ажлын баримтын загваруудыг тус тус багтаасан бөгөөд ТЕЗ-ийн дотоод аудитын үйл ажиллагаанд хэрхэн хяналт тавих, төсвийн хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах талаар тодорхой заасан байна.

Дээрх хууль, журам, заавруудын дагуу Ховд аймгийн ТЕЗ-ын дотоод аудитын хяналтыг Санхүүгийн хяналт, аудитын алба гүйцэтгэн, 2021 оны байдлаар 11 орон тоотойгоор 213.6 сая төгрөгийн төсөвтэй, 77 төсөвт байгууллагад хяналт шалгалт хийхээр төлөвлөгөөгөө батлуулан ажиллаж байна.

Ховд аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа 247 төсөвт болон төрийн өмчит байгууллагуудаас Хүнс хөдөө аж ахуйн газар, Ховд дулааны станц төрийн өмчит үйлдвэрийн газар, Мянган Угалзат ОНӨААТҮГ тус тус 1 дотоод аудитор ажиллуулж байна. Харин Ховд их сургууль, МХГ нь орон тооны бус 3 хүний бүрэлдэхүүнтэй дотоод аудитын нэгжийг байгуулан ажиллаж байна.

**БҮЛЭГ 1. Дотоод аудитыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин оновчтой бүрдээгүй, Санхүүгийн хяналт, аудитын алба нь Төрийн албаны тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт зарлаагүй, үйл ажиллагааг хараат бусаар явуулаагүй байна.**

**Төсвийн тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хуулиар санхүүгийн хяналт, шалгалтыг хуульчилж өгсөн ч дотоод аудитыг хэрхэн явуулах эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байна.**

- 1.1.1 Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10<sup>1</sup>, 69 дүгээр зүйлийн 69.1<sup>2</sup>-д заасны дагуу Ховд аймгийн Засаг даргын 2014 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/577 тоот захирамжаар “Санхүүгийн хяналт, аудитын алба”-ыг 6 хүний бүтэц орон тоотойгоор анх байгуулагдсан байна. Тус байгууллагын орон тооны бүтцэд 2 удаа өөрчлөлт орж Монгол улсын хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх эрхэм зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.
- 1.1.2 Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3<sup>3</sup>, Сангийн сайдын 2016 оны 107 тоот тушаалаар “Санхүүгийн хяналт, шалгалтын стандарт” -ын дагуу санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, Олон улсын мэргэжлийн практикийн стандартад дотоод аудит нь санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бус эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэгдэнэ гэсэн заалт, Төсвийн тухай хуулийн 69.2<sup>4</sup>, Сангийн сайдын 2015 оны 348 тоот “Байгууллагын эрсдэлийн удирдлагад дотоод аудитыг нэвтрүүлэх заавар”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Иймд дотоод аудитын эрх зүйн зохицуулалтын хувьд бие даасан дотоод аудитын үйл ажиллагааг зохицуулах хуультай болох шаардлагатай байна.
- 1.1.3 Санхүүгийн хяналт, аудитын албаны үйл ажиллагааны санхүүгийн хяналт нь Төрийн хяналт, шалгалтын тухай хуулиар зохицуулагдаж дотоод аудит нь ямар нэг хууль эрхийн актаар зохицуулагдаагүй байна. Иймд Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу Дотоод аудитын үйл ажиллагааг зохицуулах хуулийг боловсруулах шаардлагатай байна.
- 1.1.4 Аймгийн засаг дарга нь Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 8.2.1<sup>5</sup>-д заасан харьяа байгууллагуудаа дотоод хяналтыг хэрэгжүүлэх журмыг батлаагүй байна.

<sup>1</sup> Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх

<sup>2</sup> Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

<sup>3</sup> Засгийн газар, яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хорооны Засаг даргын хяналт шалгалт, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгогдсон мэргэжлийн хяналт, түүнчлэн нутгийн өөрөө удирдах байгууллагаас энэ хуулийн дагуу хэрэгжүүлэх хяналт шалгалттай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

<sup>4</sup> Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангана.

<sup>5</sup> Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн өөрийн болон доод шатны Засаг даргын ажлын алба, харьяа байгууллага, аж ахуйн нэгжид дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж мөрдүүлэх

- 1.1.5 Засгийн газрын 2015 оны 483 тоот тогтоолын 4.3<sup>6</sup>-дахь заалтын дагуу Ховд Дулааны станц ТӨХК, “Мянган-Угалзат” ОНӨААТҮГ, ХХААГ зэрэг 3 байгууллага дотоод аудиторын орон тооны ажилтан ажиллуулж байна. Харин Ховд Их сургууль, МХГ зэрэг байгууллагууд орон тооны бус дотоод аудитын нэгжийг даргын тушаалаар томилон байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.
- 1.1.6 Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан дотоод аудитын дүрэмд улсын /ахлах/ байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл түүнийг хүлээн авснаас хойш 10 хоногт багтаан санхүүгийн хяналт шалгалтын улсын ерөнхий байцаагч болох Сангийн сайдад гомдол гаргаж шийдвэрлүүлэх, тус шийдвэрийг эс зөвшөөрвөл 30 хоногийн дотор шүүхэд хандахаар заасан. Гэтэл тухайн хугацаа өнгөрч Санхүүгийн хяналт аудитын албаны /ахлах/ байцаагчийн төлбөрийн акт хүчин төгөлдөр болсон боловч он удаан жил төлөгдөхгүй байгаа болон хариуцагч нь нас барсан буюу харьяатаас гарсан төлбөрийн актыг дотоод аудитын хороогоор хэлэлцэж актын төлбөрөөс чөлөөлж байгаа нь хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох өөрийн бие даасан хуультай болох хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.
- 1.1.7 Санхүүгийн хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллахдаа илэрсэн алдаа зөрчилд төлбөрийн акт, албан шаардлага бичихдээ Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон Засгийн газрын 2015 оны 483 тоот тогтоолыг үндэслэжээ. Гэвч ямар алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоох, ямар зөрчилд албан шаардлага өгөх нь тодорхойгүй, хууль эрх зүйн актаар баталгаажаагүйгээс эрсдэл учирч болзошгүй тул Сангийн яамнаас нэгдсэн бодлогоор журам гаргах шаардлага байгааг харуулж байна.

***Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан дотоод аудитын дүрэм нь мэргэжлийн практикийн олон улсын стандарт, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, шийдвэрүүдтэй уялдаагүй, шинэчлэн батлуулаагүй байна***

- 1.2.1 Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт 1000-д “Дотоод аудитын нэгжийн зориулалт, эрх мэдэл, үүрэг хариуцлагыг Дотоод аудитын тодорхойлолт, ёс зүйн дүрэм, Стандартуудад нийцсэн Дотоод аудитын дүрэмд албан ёсоор тодорхойлох ёстой. Аудитын гүйцэтгэх удирдлага Дотоод аудитын дүрмийг үе үе эргэн хянаж, ахлах удирдлага болон зөвлөлд танилцуулан батлуулж байх ёстой” гэж заажээ. Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2014 оны 11 сарын 10-ны өдөр аймгийн Засаг даргын А/577 тоот захирамжаар дотоод аудитын дүрмийг батлуулснаас хойш ямар нэгэн өөрчлөлт оруулаагүй 7 жил болсон байна.
- 1.2.2 Тус албаны үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрмийн зарим заалт нь Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт, Засгийн газар, Сангийн сайдын гаргасан тогтоол, шийдвэрүүдтэй уялдаагүй байна. Тухайлбал:
- *Засгийн газрын 2015 оны 483 тоот тогтоолоор Дотоод аудитын дүрмийг шинэчлэн батлагдсантай холбогдуулан Аймгийн Дотоод аудитын хорооноос дотоод аудитын дүрмийг шинэчлэн батлаагүй,*
  - *Тус дүрмийн 5.2-т “Санхүүгийн хяналт, аудитын үйл ажиллагаа нь холбогдох хууль, тогтоомж болон дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартад нийцсэн, санхүү, төсвийн асуудал хариуцсан захиргааны төв байгууллагаас баталсан стандарт, арга зүйн хүрээнд явагдана” гэж заасныг мөрдөж хэрэгжүүлсэн дотоод аудитын тайлан, мэдээ, судалгаагүй,*

<sup>6</sup> Төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч нь өөрийн хариуцах асуудлын хамрах хүрээнээс шалтгаалан дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх дотоод аудитор ажиллуулж болно.



- Дотоод аудитын дүрэмд ёс зүйн дүрэм, дотоод аудитын нэгжийн зорилго, эрх үүрэг зэргийг дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартад нийцүүлэн тусгаагүй,
- Чанарын ба сайжруулалтын хөтөлбөрийг дүрэмд тусгаагүй байна.
- Сангийн сайдын 2015 оны 348 тоот тушаалаар “Байгууллагын эрсдэлийн удирдлагад дотоод аудитыг нэвтрүүлэх заавар”-ыг мөрдөөгүй байна.

**Төсвийн ерөнхийлөн захирагчаас дотоод аудитыг хэрэгжүүлэх орон тоо, төсвийг баталсан ч Төрийн албаны тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй, дотоод аудиторт тавигдах шалгуур, ажлын байрны шалгуурыг хангахгүй албан хаагчдыг томилон ажиллуулж байна.**

1.3.1 Санхүүгийн хяналт, аудитын албыг 2014 оны 11 сарын 10-ны өдрийн аймгийн Засаг даргын А/577 тоот захирамжаар албаны дарга 1, улсын байцаагч 4, улсын байцаагч, нягтлан бодогч, дотоод ажил, архив, бичиг хэрэг хариуцсан ажилтан 1 нийт 6 орон тоотойгоор анх байгуулжээ. 2018 оны А/498 тоот захирамжаар нийт 8 орон тоотойгоор бүтэц, орон тоог шинэчлэн баталж, 2020 оны 09 сарын 16-ны өдрийн А/514 тоот захирамжаар, дарга 1, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч 1, Ахлах дотоод аудитор 1, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч 3, дотоод аудитор 3, дотоод ажилтан 1, жолооч 1 нийт 11 орон тоотой байхаар бүтэц орон тоог шинэчлэн баталжээ.



Харин Сангийн яамнаас тус албаны орон тоог үндсэн 6, гэрээт 2 байхаар хянасныг Баруун 5 аймгуудын батлагдсан орон тоотой харьцуулахад 1-5 орон тоогоор илүү байна.

Байгууллагын бүтэц орон тоог дээрх захирамжуудаар нэмэгдүүлэн баталсан нь тус алба хуулиар хүлээсэн чиг үүргээ хангалттай хэрэгжүүлэх хүний нөөц, төсвийг аймгийн ТЭЗ-аас бүрдүүлсэн байна.

1.3.2 Аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн Б/21 дүгээр захирамжаар аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтнийг Санхүүгийн хяналт аудитын албаны даргын албан тушаалд 2 жилийн хугацаагаар сэлгэн ажиллуулахаар томилсон нь Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаар тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 1.5<sup>7</sup> дахь заалт, мөн сэлгэн ажиллуулах хугацаа дуусмагц 2021 оны 06 дугаар сарын 02-ны Б/17 дугаар захирамжаар шилжүүлэн томилсон нь тус журмын 1.4<sup>8</sup>, 1.5 дахь заалт, мөн Төрийн албаны тухай хуулийн 25.1<sup>9</sup> заалтыг зөрчиж сонгон шалгаруулалтад хамруулахгүйгээр удирдах албан тушаалд томилсон хууль, журамд нийцэхгүй байна.

1.3.3 Санхүүгийн хяналт аудитын албанд 2019 онд 2 ажилтан, 2020 онд 1 ажилтан, 2021 онд шинээр 6 ажилтан, нийт 9 ажилтан томилж, 2 ажилтан өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж, 2 ажилтан чөлөө авч, 1 ажилтан тэтгэвэрт гарч, 4 ажилтан шинээр

<sup>7</sup> Төрийн жинхэнэ албан хаагчийг адил төрлийн албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулна.

<sup>8</sup> Энэ журам зааснаас бусад зорилгоор төрийн жинхэнэ албан хаагчийг өөр байгууллага, албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулахыг хориглоно.

<sup>9</sup> Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалд энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг сонгон шалгаруулж томилно.

томилогджээ. Зарим шинээр томилогдсон ажилтан нар нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан дотоод аудитын дүрмийн 4.4<sup>10</sup> дахь заалт, шалгуурыг хангаагүй байна.

Шинээр ажилтан авахдаа Төрийн албаны тухай хуулийн 27.2<sup>11</sup> дахь заалтыг зөрчин төрийн албаны зөвлөлд сул орон тооны захиалгыг өгөөгүй, гэрээт ажилтнаар томилон ажиллуулж байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй байна.

Аймгийн төрийн албаны салбар зөвлөлд 2021 оны 8 сард 1 ажлын байрны захиалга өгсөн байна.

1.3.4 Байгууллагаас ажилчдын мэдлэг боловсрол ур чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөө баталсан ч хэрэгжүүлээгүй, ажлын байрны шалгуурыг хангасан ажилтан аваагүйгээс ажилчдын ажлын үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал: 2021 онд тус байгууллага нь 96.0 сая төгрөгийн төлбөрийн акт бичигдсэнээс шинээр орсон ажилтнууд нь нийт бичигдсэн актын 18% буюу 17.3 сая, тус байгууллагуудад урд нь ажиллаж байсан ажилчид нь 82 хувь буюу 78.7 сая төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт бичсэн байна.

Орон нутагт дотоод аудиторар мэргэшсэн, сургалтад хамрагдсан албан хаагч байхгүй тул дотоод аудиторыг бэлтгэх сургалтыг Сангийн яам болон холбогдох бусад байгууллагуудад хандан боловсон хүчний чадавхыг сайжруулах шаардлагатай байна.

1.3.5 Санхүүгийн хяналт шалгалтын стандарт, дотоод аудитын стандартууд нь өөр байхад байгууллагын ажилчдын албан тушаалын тодорхойлолтыг нэгэн ижил батлуулж гүйцэтгэх ажлын чиг үүргийг нарийвчлан тусгаагүй байна.

1.3.6 Санхүүгийн хяналт, аудитын албаны төсөв 2019 онд 128.6 сая, 2020 онд 145.3 сая, 2021 онд 213.6 сая төгрөгөөр баталж 2020 онд төсвийг 16.7 сая төгрөгөөр 2021 онд 68.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. 2021 онд орон тоог нэмэгдүүлэн баталсантай холбоотойгоор баруун бүсийн аймгуудаас 33.8-88.6 сая төгрөгөөр илүү төсвийг баталжээ.

Хүснэгт 1

№	Аймгийн нэр	Нийт төсөв					
		2019		2020		2021	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл /2021.09.30-рх/
1	Говь-Алтай	119.16	118.57	123.80	122.90	126.80	89.90
2	Завхан	163.30	163.60	188.40	186.80	179.80	128.00
3	Увс	115.09	115.09	169.01	163.85	164.04	135.52
4	Ховд	128.61	128.61	145.29	0.4 сая,	213.57	149.62
5	Баян-Өлгий	150.97	150.97	119.43	113.40	125.01	86.60
<b>НИЙТ</b>		<b>677.13</b>	<b>676.84</b>	<b>745.92</b>	<b>586.95</b>	<b>809.22</b>	<b>589.64</b>

1.3.7 Байгууллагын албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөө жилээр батлуулж ажилдаг боловч гүйцэтгэлийн үнэлгээг улирал бүр тооцуулаагүй жилийн эцсээр үнэлүүлсэн байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2020 онд жилийн эцсээр дүгнэсэн, 2021 онд аймгийн Засаг даргаар батлуулсан боловч одоог хүртэл гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаагүй нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47

<sup>10</sup> Дотоод аудитор нь санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, тухайн салбарт мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний зөвшөөрлөөр албан ёсоор зохион байгуулсан сургалтад хамрагдсан байна.


<sup>11</sup> Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.

дугаар тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх журам”-ын 1.3.1<sup>12</sup> дахь заалтыг хэрэгжүүлэхгүй байна.

1.3.8 Мянган угалзат дотоод аудитор нь Засгийн газрын 2015 оны 483 тоот тогтоолд заасан шалгуурыг хангахгүй түүхийн багш мэргэжилтэй албан тушаалтныг томилсон, Шим Ус ОНӨААТҮГ дотоод аудиторын орон тоог баталсан ч албан тушаалтан томилоогүй байна.

**Санхүүгийн хяналт, аудитын алба нь чиг үүргээ хөндлөнгийн нөлөөлөлгүй, хараат бусаар хэрэгжүүлж чадахгүй байна.**

1.4.1 Аймгийн Засаг даргын 2018 оны А/684 тоот захирамжаар дотоод аудитын хороог 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж Сангийн сайдын 2013 оны 29 тоот тушаалд заасны дагуу дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, дотоод аудитын хяналт, шалгалтын тайланг хэрэлцэх, нэгжийн үйл ажиллагаанд зөвлөгөө дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэйгээр ажиллаж байна. 2019 онд 3 удаа хуралдаж 10 тогтоол гарган 428.8 төгрөгийн зөрчлийг, 2020 онд 2 удаа хуралдаж 24 тогтоол гарган 458.3 сая төгрөгийн зөрчлийг, 2021 онд 2 удаа хуралдаж 5 тогтоол гарган 96.0 сая төгрөгийн зөрчлийг тус тус баталж акт, албан шаардлагыг баталжээ.



1.4.2 Дотоод аудитын хорооны нарийн бичгийн дарга нь Сангийн сайдын 2013 оны 29 тоот тушаалын 5.2.2<sup>13</sup>-д заасан үүргээ хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Дотоод аудитын хорооны хурлын тэмдэглэлийг албажуулаагүй бүх гишүүдээр гарын үсэг зуруулаагүй, хорооны дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь хурлын тэмдэглэл болон хурлаас гаргасан тогтоолууд нь үнэн зөв гэх үндэслэлгүй байна.

1.4.3 Санхүүгийн хяналт, аудитын алба нь өмнө нь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын бүтцэд байхдаа Улсын ахлах байцаагч 2, улсын байцаагч 4 нийт 6 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж аймгийн төсөвт байгууллагуудад 2 жилд 1 удаа санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллаж байжээ.

Санхүүгийн хяналт, аудитын алба болон аймгийн Засаг даргын эрх мэдлийн хүрээнд шилжин ирснээр бүтэц орон тоо 2 дахин нэмэгдсэн ч дотоод аудитыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхгүй байна.

1.4.4 Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1<sup>14</sup>-д захиргааны байгууллага нь шүүхийн шийдвэрийг биелүүлсний улмаас өөрт учирсан хохирлыг буцаан төлүүлэх, 103.2<sup>15</sup>-д дээд шатны дотоод аудитын нэгж хариуцан хохирлыг төлүүлэх үүргийг хариуцахаар заажээ. 2018-2020 оны хооронд Засаг даргын харьяа төсвийн байгууллагуудтай холбоотой 15 шүүхийн шийдвэрээр 76.1 сая төгрөгийг төлүүлэх шүүхийн шийдвэр гарчээ. Санхүүгийн хяналт, аудитын алба нь тэдгээр буруу шийдвэр гаргаж

<sup>12</sup> “Гүйцэтгэлийн төлөвлөгөө” гэж төрийн жинхэнэ албан хаагчаас энэ журамд заасны дагуу байгууллагын болон нэгжийн төлөвлөгөөг өөрийн албан тушаалын тодорхойлолттой уялдуулан боловсруулсан 1 улирлын хугацаанд хэрэгжүүлэх зорилт, таслал, ажил үйлчилгээний төлөвлөгөөг

<sup>13</sup> Хорооны нарийн бичгийн дарга нь хорооны хурлыг зохион байгуулах, ирцийг бүртгэх, хурлын тэмдэглэл хөтлөх, тэмдэглэлд хурлаар хэлэлцсэн асуудал, гишүүдээс гарсан санал, гаргасан шийдвэр, үүнтэй холбогдуулан зарчмын өөр саналтай гишүүний тайлбар зэргийг тусгаж хуралд оролцсон бүх гишүүдээр гарын үсэг зуруулж баталгаажуулах

<sup>14</sup> Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.

<sup>15</sup> Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна.

төрийн албан хаагчийг ажлаас халсан албан тушаалтнуудаар буцаан төлүүлэх талаар ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байгаа нь төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

1.4.5 Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын ёс зүйн дүрэм, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх шаардлагуудыг хангахгүй байна. Үүнд:

- Тус албаны дарга нь 2020 онд Зэрэг сумын сургуулийн төсөвт өөрчлөлт оруулан үдийн цайны зардлаас 10.8 сая, дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас 12.0 сая, Эрдэнэбүрэн суманд хуваарилагдсан 35.0 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг төсвийн тодотголыг Зэргийн сургуульд хуваарилан 57.8 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмжийн зардалд шилжүүлэн өөрийн дансанд оруулсан байна. Тус зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрч хуулийн байгууллагад шалгагдаж байгаагаас үзэхэд санхүүгийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх, Засгийн газрын 2019 оны 33 тоот тогтоолоор баталсан Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн 2.2<sup>16</sup> дахь заалттай зөрчсөн,
- Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга нь 2020 оны 9 дүгээр сард “Нэмэлт орлогын сангийн төсөл”-д менежерээр ажилласан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18.5.3<sup>17</sup> дугаар зүйлд заасан заалтыг зөрчиж давхар ажил эрхэлсэн,
- 2020 онд Санхүүгийн хяналт аудитын албаны улсын байцаагчтай холбоотой гомдол мэдээлэл ирснийг нягтлахад “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 2.1.2<sup>18</sup>, Төрийн албаны тухай хуулийн 37.1.7<sup>19</sup>, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6.1<sup>20</sup> дахь заалтууд тус тус зөрчигдсөн байсан тул сонсох ажиллагаа явуулж Ховд аймаг дахь Төрийн аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 42.1<sup>21</sup>-д заасны дагуу хариуцлага тооцуулах албан бичиг хүргүүлснээр тус байцаагчийн цалинг 6 сарын хугацаанд 20% бууруулах сахилгын шийтгэл оногдуулсан.
- Санхүүгийн хяналт аудитын албанаас санхүүгийн хяналт хийж гүйцэтгэсэн байгууллагын ажилтан, албан хаагчдаас “Аймгийн санхүүгийн хяналт аудитын албаны хяналт шалгалт хөндлөнгийн аливаа нөлөөлөлгүй хараат бус байж чадаж байна уу?” гэсэн санал асуулга авахад оролцсон иргэдийн 20.5 хувь буюу 9 иргэн үгүй гэж хариулсан байна. Танд болон хэн нэгэнд дотоод аудитын нэгжийн албан хаагчаас бараа, материал худалдан авах санал гаргаж байсан тохиолдол бий юу? гэсэн асуултад нийт оролцсон иргэдийн 22.7 хувь нь буюу 10 иргэн тийм гэж хариулсан байгаа нь тус албаны албан хаагчид хяналт шалгалтаар ажиллахдаа сүлжээ, болон гоо сайхны бүтээгдэхүүн, бичиг хэргийн материал шахдаг, зарж борлуулдаг гэсэн хариулт өгсөн байна.

**Санхүүгийн хяналт, аудитын албаны санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн, чиг үүрэгт тусгасан дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй байна**

<sup>16</sup> шударга ёсыг дээдэлж, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна

<sup>17</sup> ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажил, үүрэг

<sup>18</sup> шударга ёсыг дээдэлж, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна;

<sup>19</sup> төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;

<sup>20</sup> Албан тушаалтан нь хууль дээдлэх зарчимд захирагдан, албан үүргээ иргэдийн итгэл хүлээхүйц, тэгш, шударга, хариуцлагатайгаар гүйцэтгэж, албаны ёс зүйг сахина.

<sup>21</sup> ... хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

1.5.1 Аймгийн Засаг даргын 2020 оны А/514 тоот захирамжаар дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх дотоод аудитор хариуцсан ахлах 1, дотоод аудитор 3, нийт 4 орон тоог баталж 2019 онд 1, 2020 онд 1 ахлах, 2 дотоод аудитор, 2021 онд 1 ахлах 4 дотоод аудитор ажиллажээ.

Гэвч Санхүүгийн хяналт, аудитын албаны дотоод аудиторуд нь Засгийн газрын баталсан 483 тоот тогтоол болон Сангийн сайдын баталсан 348 тоот тушаалын дагуу дотоод аудитын чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаагүй хэрэгжүүлсэн дотоод аудитын тайлан мэдээ, зөвлөмжийн бүртгэл байхгүй байна.

1.5.2 Улс, орон нутгийн төсөвт 247 байгууллагаас Ховд дулааны станц ТӨХК, ХХААГ, Мянган Угалзат ОНӨААТҮГ-ууд орон тооны дотоод аудитор ажиллуулж, төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Ховд дулааны станцын дотоод аудитор ажлын тайлангаа захирлын зөвлөлийн хурал болон компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороонд тайлагнаж 2020 оны хяналт шалгалтаар 6.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж 5 албан шаардлага 1 ажилтанд хариуцлага тооцуулах саналыг хүргүүлсэн,*

- *Хүнс хөдөө аж ахуйн газрын дотоод аудитор улирал бүр шилэн дансны тухай хууль болон байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлэн тайлагнасан,*

- *Мянган-Угалзат ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын ажилтан “Нэвт”рашаан амралттай холбоотой 8, Ховд-Парктай холбоотой 11 нийт 19 зөрчил илэрч зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 19 зөвлөмж өгөгджээ.*

**БҮЛЭГ 2. Төсвийн тухай хуульд заасан ТЕЗ-ийн дотоод аудитын чиг үүрэг үр нөлөөтэй хэрэгжихгүй байна**

**Санхүүгийн хяналт, аудитын алба нь дотоод аудитын дүрэм, стандартын дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулаагүй байна.**

2.1.1 Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт, дүрмийн заалтуудын хэрэгжилт хангагдаагүй байна. Үүнд:

- *Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2014 онд байгуулагдан дотоод аудитын дүрмээ батлуулсан ч дотоод аудитын чиглэлээр ажил хэрэгжүүлээгүй нь Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын холбогдох заалтуудтай нийцэхгүй,*
- *Дотоод аудитын стандартад “Дотоод аудит нь мэргэжил болохын хувьд эрсдэл, хяналт, засаглалын талаарх дотоод аудиторын хараат бус, бодитой баталгаа, санал дүгнэлт, тайланд итгэл дээр тулгуурладаг учраас Ёс зүйн дүрмийг баримтлах шаардлагатай” гэж заасан ч тус байгууллага нь үйл ажиллагаандаа мөрдөх ёс зүйн дүрэмгүй,*
- *Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт 2010-д “Аудитыг гүйцэтгэх удирдлага байгууллагуудын зорилгуудад нийцүүлэн дотоод аудитын нэгжийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох үүднээс эрсдэлд суурилсан төлөвлөгөө гаргах ёстой” гэж зааж өгсөн боловч тус алба нь эрсдэлийн үнэлгээ хийгээгүй, эрсдэлд суурилсан аудитын төлөвлөгөөгүй,*
- *Мөн стандартын 2210.А2-т “дотоод аудиторууд ажлын зорилтуудыг тодорхойлохдоо томоохон алдаа, залилан, зөрчил болон бусад эрсдэл гарах магадлалыг судлах ёстой” гэж заасан боловч дотоод аудитын дүрэмдээ тус алба нь залилангийн эрсдэлийг илрүүлэх талаар ямар нэгэн заалт оруулаагүй байна.*



2.1.2 Засгийн газрын 2015 оны 483 тоот тогтоолын дагуу зөвлөмж хүргүүлээгүй, Сангийн сайдын 2015 оны 348 тоот тушаалын заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.1.3 Санхүүгийн хяналт, аудитын алба нь Сангийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалын дагуу 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн “Дотоод аудитын хороо байгуулах тухай” А/684 тоот тогтоолыг гаргаж 7 хүний бүрэлдэхүүнтэй дотоод аудитын хороог байгуулжээ. Дотоод аудитын хороог анх байгуулахдаа Сангийн сайдын 29 дүгээр тушаалыг зөрчжээ. Тухайлбал:

- *Хараат бус гишүүдийн тоо нь 2 байгаа нь нийт гишүүдийн гуравны нэгээс бага,*
- *Хараат бус гишүүн нь 2 жилийн хугацаагаар томилогдох бөгөөд нэг удаа улираан томилж болно гэсэн заалтыг зөрчин хараат бус 2 гишүүнийг 2018 оноос хойш улираан томилоогүй, хугацаа дууссан ч үргэлжлүүлэн ажиллуулж байна.*
- *Дотоод аудитын хорооны хуралдааны тэмдэглэлд хорооны дарга болох Засаг дарга болон хорооны гишүүн СТСХ-ийн дарга нараас өөр асуулт асууж, хариулт өгсөн тухай тэмдэглэл байхгүй байна.*

2.1.4 Дотоод аудитын хорооны 2018 онд Санхүүгийн хяналт, аудитын албаны 2018-2020 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг 06 тоот тогтоолоор баталжээ. Тус тогтоолын 5-д “Эрсдэлийн үнэлгээ”-г тусад нь 8 шалгуур үзүүлэлтээр тооцож 1-10 оноогоор үнэлж их эрсдэлтэй байгууллагад жилд 1 удаа, дунд эрсдэлтэй байгууллагад 2 жилд 1 удаа, бага эрсдэлтэй байгууллагад 3 жилд 1 удаа шалгалт хийхээр баталжээ. Гэвч тус байгууллага нь 2019, 2020, 2021 онуудад хийх хяналт шалгалтын төлөвлөгөөндөө эрсдэлийг үнэлээгүй, санхүүгийн хяналт шалгалт хийгдсэн хугацаагаар нь хяналт хийх байгууллагуудаа сонгон санхүүгийн хяналтыг хэрэгжүүлжээ.

***Санхүүгийн хяналт аудитын алба дотоод аудитын чиг үүргээ хэрэгжүүлээгүй, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.***

2.2.1 Санхүүгийн хяналт, аудитын алба нь Сангийн сайдын 2016 оны 107 тоот тушаалын хүрээнд санхүүгийн хяналт, шалгалтын стандартыг мөрдөн ажиллаж дараах ажлуудыг хэрэгжүүлжээ.

- *2018 онд 8 сумын 56, аймгийн төвийн 30 төсөвт байгууллага 2 ОНӨААТҮГ нийт 87 байгууллагад хяналт шалгалт хийхээр төлөвлөж гүйцэтгэлээр 4 сумын 23, аймгийн төвийн 34 байгууллага нийт 57 байгууллагад хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн,*
- *2019 онд 9 сумын 63, аймгийн төвийн 12 төсөвт байгууллага, 2 ОНӨААТҮГ нийт 77 байгууллагад хяналт шалгалт хийхээр төлөвлөж, 69 байгууллагад хяналт шалгалт хийхээс 60 байгууллагад хяналтыг хэрэгжүүлсэн,*
- *2020 онд 6 сумын 36, Жаргалант сумын ЗДТГ, ИТХ, тусгай сангууд, аймгийн төвийн 15, Сангийн яам, ХХААХҮЯ-ны захиалгаар 2 байгууллага нийт 55 байгууллагад хяналт шалгалт хийхээр батлагдсанаас 5 сумын 30 байгууллага, Жаргалант сумын ЗДТГ, ИТХ, тусгай сангууд болон аймгийн төвийн 17 байгууллагад хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна.*

Батлагдсан хяналт, шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хянахад 2018 онд 30 байгууллага, 2019 онд 9 байгууллага, 2020 онд 4 байгууллагад хяналтыг хэрэгжүүлээгүй нь Дотоод аудитын хорооноос баталсан төлөвлөгөөт хяналт шалгалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Мөн 2018 онд нийт 57, 2019 онд 60, 2020 онд 51 байгууллагад хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажилласан ч сургалт, арга зүйгээр ханган зөвлөн туслах чиг үүргээ хэрэгжүүлээгүй, цаашид авах арга хэмжээний саналыг хүргүүлсэн ч үйл ажиллагааны

тайлан, мэдээний маягтад албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүртгэх маягт байхгүй байна.

2.2.2 2019 онд тус байгуулга нь 128.6 сая төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 128.6 сая төгрөгийг зарцуулжээ. 2020 онд 145.3 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 145.3 сая төгрөгийг зарцуулсан, 2021 онд 213.6 сая төгрөгийн төсөв батлагджээ. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна. Тухайлбал:

- 2020 онд тус алба нь санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалтай санал дүгнэлт авчээ. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6 зөвлөмж өгөгдсөн ч хэрэгжүүлээгүй, алдааг давтан гаргасан байгаа нь санхүүгийн сахилга бат хяналтын байгууллагын хувьд хангалтгүй байна. И-баримтаар нотлогдоогүй ажил гүйлгээг санхүүжүүлэхгүй байх зөвлөмж өгөгдсөн ч 2021 онд И-баримтгүй шатахууны ажил гүйлгээг санхүүжүүлсэн, замын хуудас бичүүлээгүй алдаа зөрчлүүдийг арилгаагүй,
- 2021 оны санхүүгийн тайлангийн засварын аудитаар шатахууны тооцоо бодоогүй, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн алдаа зөрчил илэрчээ.

2.2.3 Байгууллагын удирдлагаас хүний нөөцийн оновчтой бодлого хэрэгжүүлээгүйгээс тус албаны нягтлан бодогч 2021 онд 3 удаа солигдож, байгууллагын санхүүгийн анхан шатны баримт бичгийн бүрдүүлэлт хангалтгүй, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахгүй байгаа нь бусад төсөвт байгууллагуудад үлгэр жишээ болох байгууллагын хувьд туйлын хангалтгүй байна.

**Дотоод аудитын нэгж үйл ажиллагаагаа хараат бусаар удирдах, хэрэгжүүлэх, хянах, тайлагнах нөхцөл бүрэн бүрдээгүй байна**

2.3.1 Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт 1110-1, хөндлөнгийн нөлөөнөөс ангид байх талаар, Дотоод аудитын дүрмийн 7.7-д<sup>22</sup>, Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ын 5.1-д<sup>23</sup> тус тус хараат бусаар хяналт шалгалт явуулахаар заасан.

Мөн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуулиуд болон Дотоод аудитын дүрмийн 6.2-д<sup>24</sup> 6.2.5<sup>25</sup>-д”, 6.2.6<sup>26</sup>-д дотоод аудиторын нууц хадгалах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар ашиг сонирхлын зөрчилгүй мэдүүлэг гаргасан байна.

2.3.2 Тус алба нь санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллаж төлбөрийн акт бичихдээ эрх ашиг нь хөндөгдсөн хөндөгдсөн этгээдэд Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1<sup>27</sup>-д заасны дагуу сонсох ажиллагааг зохион байгуулаагүй байна. 2021 оноос эхлэн хуульд заасан сонсох ажиллагааг акт бүрд явуулж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны даргыг Аймгийн засаг дарга томилохоор Төсвийн тухай хуульд заажээ. Санхүүгийн хяналт шалгалтыг Сангийн сайдын 107 тоот

<sup>22</sup> “Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, дотоод аудитор нь хяналт шалгалтын тайланг бэлтгэн нэгжийн даргад танилцуулна. Хэрэв Дотоод аудитын хороотой бол тайланг тус хороогоор хэлэлцүүлнэ”

<sup>23</sup> “Хяналт шалгалтын байгууллагын зохион байгуулалтын хараат бус байдал”-ыг Санхүүгийн хяналт шалгалт явуулж байгаа газар зохион байгуулалт, эрх зүйн байдал хяналт шалгалт явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна

<sup>24</sup> 6.2.2-д “Аудитын явцад олж авсан мэдээллийг нууцыг хадгалах”,

<sup>25</sup> “Аливаа асуудалд шударга, бодит байдалд нийцүүлэн хандаж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах

<sup>26</sup> “Аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар дотоод аудитын нэгжийн дарга болон төсвийн ерөнхийлөн захирагчид мэдээлэх

<sup>27</sup> Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно.

стандартын 5-д заасан хараат бус байх гэсэн зарчмыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна. Тухайлбал: Тус алба нь Аймгийн ЗДТГ болон Засаг дарга гарын үсэг зурдаг сангуудыг үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш хяналт, шалгалтын үйл ажиллагаа явуулаагүй байна

2.3.3 Тус албаны 2020 оны явсан бичигт нэр бүхий 8 байгууллагад төлөгдөөгүй актын үлдэгдлийг холбогдох зардлаас гаргаж барагдуул гэсэн албан бичиг хүргүүлсэн нь актын төлбөрийн биелэлтийг хангуулахдаа өөрийн эрх хэмжээнээс хэтрүүлж тухайн байгууллагын санхүүгийн дотоод үйл ажиллагаанд хөндлөнгөөс хэт нөлөөлсөн хууль бус захиргааны албадлагын арга хэмжээ авсан байж болзошгүй байна.

2.3.4 Дотоод аудитын хорооны хурлаар орж баталгаажуулаагүй 51.3 сая төгрөгийн төлбөрийн актыг 2021 оны 7,8 сард актын орлогын дансанд төвлөрчээ. Энэ нь санхүүгийн хяналт шалгалтын стандартын 3.4.12<sup>28</sup>-д заасан стандарттай нийцээгүй, Дотоод аудитын хороог тухайн хяналт шалгалт дууссан тухай бүрд нь зарлан хуралдуулдаггүйтэй холбоотой байна.

***Санхүүгийн хяналт, аудитын алба нь санхүүгийн хяналт, шалгалтын тайланг цахим сайтад байршуулахаар бие даасан сайттай болсон ч мэдээллийг ил тодоор иж бүрэн мэдээлээгүй байна.***

2.4.1 Санхүүгийн хяналт, аудитын алба нь [sankhuu.kho.gov.mn](http://sankhuu.kho.gov.mn) сайтыг 2018 оноос эхлэн үйл ажиллагаандаа нэвтрүүлжээ. Тус сайтад үйл ажиллагааны тайлан 12, хяналт шалгалтын тайлан 16, цаг үеийн мэдээлэл 15, дотоод аудитын хорооны хуралдааны талаарх мэдээлэл 5 байршуулсан байна. 2021 оны 1 дүгээр сараас хойш тус сайтад мэдээлэл байршуулаагүй байгаа нь ард иргэд хяналт, шалгалтын талаарх мэдээлэл авах боломжгүй байна.

Мөн Ховд их сургууль, Ховд дулааны станц ТӨХК, Мянган-Угалзат ОНӨААТҮГ, Хүнс, хөдөө аж ахуйн газруудын өөрийн сайтаараа дамжуулан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын талаарх ямар нэгэн мэдээллийг байршуулаагүй байна.

***Санхүүгийн хяналт, аудитын алба нь дотоод аудитын дүрэмдээ заасан хөндлөнгийн аудитын байгууллагуудтай хамтран ажиллах заалтын хэрэгжилт хангагдаж байна.***

2.5.1 Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд хэрэгжүүлэхээр заасан төсвийн захирагч нарын санхүүгийн хяналтаар илэрсэн акт, албан шаардлагын нэгдсэн мэдээ, судалгааг Төрийн аудитын байгууллагад хүргүүлэн мэдээлэл солилцож байна.

Харин аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 247 төсөвт болон төрийн, орон нутгийн өмчид аж хуйн нэгжүүдээс дотоод аудитор болон, дотоод аудитын нэгжтэй байгууллагуудтай хоорондоо мэдээлэл солилцоогүй, хяналт шалгалт хийсэн байгууллагынхаа дотоод хяналтын тогтолцоог үнэлсэн талаарх мэдээлэл байхгүй байна.

***Чанарын үнэлгээгээр өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, стандартад заасан чанарын баталгаажуулалт ба сайжруулалтын хөтөлбөрийг баталж үйл ажиллагаандаа мөрдөөгүй байна.***

2.6.1 2016 онд Санхүүгийн хяналт, аудитын албаны үйл ажиллагаанд Сангийн яам, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Дотоод аудитын чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд Монголын Дотоод Аудиторуудын холбооноос чанарын үнэлгээ хийжээ. Тус чанарын үнэлгээгээр 31 заалт бүхий зөвлөмжийг өгсөн байна. Эдгээрээс нийт 20 зөвлөмж буюу 64 хувийг хэрэгжүүлээгүй байна.

- Албаны дүрмийг шинэчлэн боловсруулах, батлуулахтай холбоотой 4 зөвлөмж
- Санхүүгийн хяналт, шалгалтын ажлаас дотоод аудитын ажилд шилжих

<sup>28</sup> Улсын байцаагч нь хяналт, шалгалт явуулсан тухай бүрд шалгалтын тэмдэглэл, нэг бүрчилсэн актадаа тулгуурлан танилцуулга бичиж дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэхээр оруулна. Дээрх хурлаар шалгалтын дүнг хэлэлцэн дүгнэж, улсын байцаагчийн актыг батална.



- Жил бүр албаны сургалт, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, шинэ ажилтны сургалттай холбоотой 3 зөвлөмж
- Ажлын гүйцэтгэлтэй холбоотой 8 зөвлөмж
- Тус аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй босоо удирдлагатай байгууллагуудад дотоод аудитыг хэрхэн хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагч нартай нь санал солилцож хамтран ажиллах
- Нийт ажилтнуудын дотоод аудитын гүйцэтгэл, тайлагналыг сайжруулах үүднээс дотоод аудит сайн хөгжсөн аль нэг байгууллагын иж бүрэн тайлантай танилцах, туршлага судлах
- Хяналт шалгалтаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийн бүртгэлтэй холбоотой 2 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

2.6.2 Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт 1300-д “Аудитын гүйцэтгэх удирдлага дотоод аудитын нэгжийн чанарын баталгаажуулалт ба сайжруулалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ёстой” гэж заасан боловч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх төлөвлөгөөгүй байна. Мөн стандарт 1311-д “Өөрийгөө үнэлэх замаар буюу эсвэл дотоод аудитын практикийн талаар хангалттай мэдлэгтэй байгууллагын бусад ажилтнуудаар үе үе хянуулах” гэж заасан боловч дотоод үнэлгээг үйл ажиллагаандаа хэрэгжүүлээгүй байна.

2.6.3 Засгийн газрын 2015 оны 483 тоот тогтоолын 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэсэн заалтыг зөрчин 2016 оноос хойш хөндлөнгийн чанарын үнэлгээг тус албанд хэрэгжүүлээгүй байна.


**Санхүүгийн хяналт, аудитын алба нь зөрчлийг арилгуулах албан шаардлагын хэрэгжилтийн бүрэн хангуулаагүй, зөвлөмж өгсөн боловч Дотоод аудитын хороонд танилцуулж тогтоолоор баталгаажуулаагүй, зөвлөмжийг бүртгээгүйгээс байгууллагаас ирүүлсэн цаашид авах арга хэмжээний саналын хэрэгжилтийг үнэлж тайлан мэдээнд тусгаагүй байна.**

2.7.1 Санхүүгийн хяналт, аудитын алба нь Сангийн сайдын 107 тоот тушаалын дагуу үйл ажиллагаандаа санхүүгийн хяналт шалгалтын стандартыг мөрдөн санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлжээ. Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн төлбөрийн акт, албан шаардлагыг Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн баталж төсөвт байгууллага болон ОНӨААТҮГ-дад хүргүүлэн ажилласан ч албан шаардлагын биелэлтийг тооцсон талаар ямар нэгэн судалгаа, баримт байхгүй байна. Хяналт шалгалтын танилцуулгад зөвлөмж бичин шалгагдагч байгууллагад хүргүүлсэн боловч бүртгээгүй, дотоод аудитын хороогоор оруулж батлуулаагүй байна.

- 2019 онд 60 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийж 202 төлбөрийн актаар 180.0 сая, 16 албан шаардлагаар 249.1 сая, нийт 429.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлжээ. Өмнөх оны актын үлдэгдэл 407.8 сая төгрөг байсан бол тайлант онд төрийн сангийн харилцах дансаар 101.8 сая төгрөгийн актын төлбөрийн орлого орж 158.1 сая төгрөгийн актыг тухайн байгууллагад орж 327.9 сая төгрөгийн актын үлдэгдэлтэй,
- 2020 онд Санхүүгийн хяналт шалгалтаар нийтдээ 55 байгууллагад төлөвлөгөөт хяналт 2 байгууллагад төлөвлөгөөт бус шалгалт хийж, 254 актаар орон нутгийн төсвийн орлогод 175.0 сая төгрөг, тухайн байгууллагын төсөвт орох, нөхөн олгох, сум хөгжүүлэх сангийн төсөвт оруулахаар 136.5 сая

төгрөгийн, нийт 311.5 сая, 5 албан шаардлагаар 146.8 сая, нийт 458.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлсэн,

- 2020 онд нас барсан иргэдтэй холбоотой 10.4 сая, эзэн холбогдогч нь тодорхойгүй 4.2 сая, иргэний өргөдөл гомдлын дагуу 7.0 сая төгрөгийн төлбөрийн актыг Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн данс бүртгэлээс хасаж төрийн сангийн харилцах дансаар 141.6 сая төгрөгийн актын төлбөрийн орлого орж тухайн байгууллагад орох 86.0 сая төгрөгийн акт барагдаж оны эцэст 383.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- 2021 оны эхний 9 сарын байдлаар 96.0 сая төгрөгийн төлбөрийн акт бичигдэж орон нутгийн төсвийн орлогын дансанд 104.3 сая төгрөгийн актын төлбөр төлөгджээ.



2.7.3 Тус алба нь 2014 онд байгуулагдсан цагаасаа эхлэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллахдаа акт, албан шаардлага, зөвлөмжийг өгч ажилласан боловч 2019-2020 онуудад нийт 395.9 сая төгрөгийн албан шаардлагыг өгсөн гэж бүртгэсэн боловч хэрэгжилтийг хянаагүй, цаашид авах арга хэмжээний саналыг хэрэгжүүлэн ажилласан талаар шалгагдагч байгууллагаас албан тоотоор хариуг ирүүлдэг боловч бүртгээгүйгээс албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжилтийг тайлан мэдээнд тусгаагүй байна.

**Санхүүгийн хяналт, аудитын алба нь санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллахдаа төсөвт байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах талаар тодорхой ажил хийгээгүй байна.**

2.8.1 Санхүүгийн хяналт, аудитын алба нь санхүүгийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэн ажиллахдаа Засгийн газраас гаргасан тогтоолыг зөрчин шалгагдагч байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар зөвлөмжийг өгсөн боловч хэрэгжилтийг хянаагүй байна.

“Ховд дулааны станц” ТӨХК нь илэрсэн зөрчлийг яаж арилгах цаашид үйл ажиллагаагаа сайжруулахад анхаарах асуудлын талаар тусгаж удирдах зөвлөлдөө танилцуулан батлуулж, тогтоол гаргуулан ажилласан байна. Байгууллагын захирал нь ТУЗ-ын тогтоолын дагуу үйл ажиллагаандаа өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байгаа нь үр дүнтэй ажил болжээ.

**Аудитаар нийт 76100 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1 албан шаардлага, 76100.0 мянган төгрөгийн 15 зөвлөмж бичигдлээ.**

**ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:**

- **Дотоод аудитыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин оновчтой бүрдээгүй, Санхүүгийн хяналт, аудитын алба нь Төрийн албаны тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт зарлаагүй, үйл ажиллагааг хараат бусаар явуулаагүй байна.**
- **Төсвийн тухай хуульд заасан ТЕЗ-ийн дотоод аудитын чиг үүрэг үр нөлөөтэй хэрэгжихгүй байна.**

### **ҮАГ-т уламжлах санал:**

1. Санхүүгийн хяналтын чиг үүрэг нь Мэргэжлийн хяналтын газрын бүтцэд байхдаа санхүүгийн хяналт шалгалтыг хараат бусаар хэрэгжүүлдэг, Төрийн аудитын байгууллагатай уялдаатай ажиллаж хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлдэг байсан боловч 2014 оноос Аймгийн Засаг даргын дэргэдэх “Санхүүгийн хяналт, аудитын алба” болсноор хараат бусаар ажиллах зарчим алдагдаж байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаныг бүтцийг нэгтгэснээр Дотоод аудитын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль заасны дагуу ТЕЗ-ын дотоод хяналтын чиг үүрэг хэрэгжихгүй байна. Иймд Санхүүгийн хяналт, аудитын албаны бүтцээс санхүүгийн хяналтыг Мэргэжлийн хяналтын газарт шилжүүлэх, дотоод аудитын чиг үүргийг ТЕЗ-ын дэргэдэх дотоод аудитын нэгж байгуулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2. Санхүүгийн хяналт шалгалт нь ихэвчлэн 1 ба түүнээс өмнөх жилийн баримт шалгагддаг учир санхүүгийн зөрчил гаргасан албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулахад Хөдөлмөрийн тухай хуулийн 131.2 дахь заалтын хугацаа өнгөрсөн байдаг тул тус заалтад “санхүүгийн зөрчил гаргаснаас бусад тохиолдолд” гэсэн нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

## **АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

### ***Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн Аймгийн Засаг дарга, Дотоод аудитын хорооны дарга Б.Дүгэржав танаа***

1. Дотоод аудитын хороог шинэчлэн байгуулж, хорооны үйл ажиллагааг Засгийн газрын 2015 оны 483 тоот тогтоолыг мөрдөн үр нөлөөтэй зохион байгуулан ажиллах
2. Санхүүгийн хяналт, аудитын албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дотоод аудитын чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг тусгайлан баталж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллах
3. Төсвийн захирагч нарт чиглэл хүргүүлэн дотоод хяналтын нэгжийг орон тооны бусаар тушаалаар томилон, дотоод хяналтын үр нөлөөт тогтолцоог зохион байгуулах
4. Засгийн газраас гаргасан нийтлэг журмыг үндэслэн ТТЗ, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан үйл ажиллагаанд нь мөрдүүлэн ажиллах

### ***Төрийн албаны салбар зөвлөлийн дарга Д.Энхболд танаа***

1. Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга болон томилогдсон шинэ ажилтнууд нь Төрийн албаны тухай хуулийг зөрчиж байгаа тул сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлан зохион байгуулах

### **Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Г.Өөдэй танаа**

1. Байгууллагын стратегийн төлөвлөгөө, дотоод аудитын дүрэм, ёс зүйн дүрмийг , Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн батлуулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах
2. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдүүлэн, албан хаагчдын мэргэжил ур чадварыг дээшлүүлэх талаар тодорхой ажлуудыг зохион байгуулан ажиллах

3. Төрийн албаны тухай хуульд заасны дагуу байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг улирлаар биелэлтийг тайлагнаж байх
4. Хяналт, шалгалтын жилийн төлөвлөгөөг батлуулахдаа эрсдэлд суурилж өндөр эрсдэлтэй байгууллагуудыг бүрэн хамруулж хэвших
5. Захиргааны ерөнхий хуулийг мөрдөн ажиллаж шүүхийн шийдвэрээр байгууллагаас төлсөн хохирлыг бураатай албан тушаалтнаар буцаан төлүүлж төсвийг хохиролгүй болгох үйл ажиллагааг зохион байгуулах
6. Хяналт шалгалтаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн нэгдсэн бүртгэл хийж, биелэлт, үр дүнг тооцож, Сангийн яамнаас 2020 онд гаргасан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-аар баталсан Аудитын албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн хянах- дотоод аудитын ажлын баримт, АБ5000 маягтыг хөтлөх.
7. Дотоод аудитын хороогоор орж баталгаажуулаагүй төлбөрийн актыг төлүүлдэг байдлыг таслан зогсоох
8. Sankhuu.kho.gov.mn сайтын үйл ажиллагааг жигдрүүлэн хяналт шалгалтын тайланг тухай бүр оруулж хэвших
9. Чанарын үнэлгээгээр өгсөн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлэн, чанарын баталгаажуулалт ба сайжруулалтын хөтөлбөрийг батлан үйл ажиллагаандаа өөрийн үнэлгээг нэвтрүүлэх

**Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын дарга Д.Отгонтуяа танаа**

1. Дотоод аудиторын албан тушаалд Засгийн газрын 2015 оны 483 тоот тогтоолд заасан шалгуурыг хангасан албан хаагчийг томилон ажиллуулах

Аудитаар өгсөн акт, зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 12 дугаар сарын 05-ны дотор гаргаж ирүүлэх

**ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР  
А.ЦЭЦЭГСҮРЭН

**ТАЙЛАН БИЧСЭН**

АХЛАХ АУДИТОР

Л.ГАЛБАДРАХ

Д.МӨНХТУЛГА

АУДИТОР

Ц.АЗЗАЯА

**ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ХОВД АЙМГИЙН  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН  
А.ЛБА

84140 Ховд, Ховд аймаг

Утас: 7043-3031

E-mail: Sankhuu\_audit\_ho@yahoo.com

2021.10.29 № 92  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Х.БОЛДБААТАР ТАНАА

Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтэнд хийсэн гүйцэтгэлийн тайлангийн төсөлтэй танилцаж, хавсралтаар санал хүргүүлж байна.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА  ТӨӨДЭЙ

D:\Doc's\Tushaasi, alban toot\A4, A5 2021\en\Alban toot



“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО  
ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТЭД” ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

1. Сургуулийн төсөвт өөрчлөлт оруулан үдийн цай болон дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас хэмнэгдсэн 57,8 сая төгрөгийг өөрийн дансанд шилжүүлсэн... гэх нь манай албаны даргад төсөвт зохицуулалт хийх эрх байхгүй, өөрийнх аавтай холбоотой асуудал учир албаны үйл ажиллагаа, дотоод аудитын үйл ажиллагаатай хамаарахгүй байна. Удаа дараагийн хувийн шинжтэй асуудлыг албаны ажилд хамаатуулсан байгааг хасч өгнө үү.

2. Нэмэлт орлогын сангийн төсөлд аймгийн Засаг даргын зөвшөөрлөөр ажил хавсран гүйцэтгэсэн. Хөдөлмөрийн хөлс аваагүй. Зөвшөөрлийн бичгийг майлээр Төсөлд хүргүүлсэн. Одоо төсөл татан буугдсан материал нь Улаанбаатар хотод тушаагдсан тул архив нь байхгүй болно. Иймд энэхүү зөрчил хэсэгт дурьдсаныг хасч өгнө үү.

3. Санхүүгийн хяналт шалгалтын стандартын 2.1.3-д хяналт шалгалт нь урьдчилан сэргийлэх /гарч болох эрсдэлээс/ илрүүлэх /хүсэж хүлээгдээгүй тохиолдлыг илрүүлж засах/ чиглүүлэх /ямар нэг ашигтай үйл явдлын суурь эхлэл болох/ хэлбэртэй байна гэж заасан байна. Мөн Санхүүгийн хяналт шалгалтын стандартын 3.4-ын 08-д цаашид зохион байгуулах, хэрэгжүүлэх ажлыг дэс дараалуулан бичнэ гэж заасны дагуу Хяналт шалгалтын тайланд цаашид авах арга хэмжээний санал гэх бүлэг болгон бичиж байгаа. Манай байгууллагын тоон тайланд зөвлөмжийн талаар байдаггүй тул тайланд тусгагдаагүй юм. Иймд зөвлөмжийн биелэлтийг хянаагүй бүртгээгүй гэсэн дүгнэлт өгсөн байгаа нь угасаа дотоод аудитыг хэрэгжүүлээгүй гэж дүгнэж байгаа дотор орсон асуудал гэж үзээд зөвлөмжийг бүртгээгүй, хэрэгжилийг хангуулаагүй, зөвлөмж өгөөгүй гэх зэрэг 2.7.1, 2.7.3, 2.8.1 дүгнэлтийг хасаж өгнө үү. Тайланд тусгагдаагүй боловч байгууллагуудаас аач хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар албан бичгээр хариу ирсэн нь жилийн ажлын тайлан баримтанд байгаа болно.

4. 2.1.6-д сонсох ажиллагаа явуулаагүй байна гэсний хувьд сонсох ажиллагааг 2021 оноос акт бүрт явуулж хэвшиж байна. 2019, 2020 оны хувьд сонсох ажиллагааг мөн явуулж ирсэн байгаа. Жишээ нь 2020 онд Дуут сумын сургуулийн хяналт шалгалтын материалаас харж болох юм.

5. 2019 онд тогтвортой амжиргаа төслөөс ОНХС-гийн гүйцэтгэлд хяналт хийн гэрээ байгуулалгүй 1000,0 мянган төгрөгийн санхүүжилт авсан талаар дурджээ. 2021 онд 3000,0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан талаар

тусгажээ Энэ нь 2019 оны санхүүгийн баримтанд гэрээ байгуулсан нь эх хувиараа байгаа бөгөөд дээрх үйлдэл нь Төсвийн тухай хуулийн 47.1, 47.1.5-ын хүрээнд явуулсан үйл ажиллагаа юм.

6. 2.2.4-д аймагт баримт материал татан авч үзэж төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хэвийн явуулахгүй байгаа талаар дурджээ 2021 оноос бусад онд сумдад газар дээр ажиллаж байсан бөгөөд төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. 2021 онд ковидтой холбоотойгоор хөл хорио тогтоосон, хурал зөвлөгөөн хийхийг хориглосон, зарим бүс нутагт хөдөлгөөн хязгаарласан, төрийн байгууллага хяналт шалгалтаар ирээд өвчин тараалаа гэх эрсдэл бодитоор байсан зэрэг онц байдалтай холбогдуулан төрийн байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явагдах зарчмын хүрээнд баримт материалыг татан авч хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн. Дээрх дүгнэлттэй санал нийлэхгүй байгаа тул хасаж өгнө үү.

7. 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг албан бичгээр хүргүүлсэн болно.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА

## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

### Саналд өгсөн тайлбар

№	Ирүүлсэн санал тайлбарын товч утга	Шийдвэрлэлт
1	Манай албаны даргад төсөвт зохицуулалт хийх эрх байхгүй, өөрийн аавтай холбоотой асуудал учир албаны үйл ажиллагаатай хамаарахгүй байна. Хувийн шинжтэй асуудлыг албаны ажилд хамаатуулсан байгааг хасаж өгнө үү.	<i>Холбогдох баримтаар нотлогдож байгаа тул тайлангаас хасах боломжгүй.</i>
2	Нэмэлт орлогын сангийн төсөлд аймгийн Засаг даргын зөвшөөрлөөр ажил хавсран гүйцэтгэсэн. Хөдөлмөрийн хөлс аваагүй. Зөвшөөрлийн бичгийг мэйлээр төсөлд хүргүүлсэн. Төсөл татан буугдаж материал нь Улаанбаатар хотод тушаагдсан архив байхгүй болно. Зөрчил хэсэгт дурдсаныг хасаж өгнө үү.	<i>НАНБХАСЗАСЗУС тухай хуулийн 18.5.3-д бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр гэж заасан байна. Бичгээр өгсөн зөвшөөрөл, ажил хавсран гүйцэтгэх шийдвэрийг ирүүлээгүй тул тайланд засвар оруулах боломжгүй.</i>
3	Зөвлөмжийн биелэлтийг хянаагүй, бүртгээгүй гэсэн дүгнэлт өгсөн байгаа нь угаасаа дотоод аудитыг хэрэгжүүлээгүй гэж дүгнэж байгаа дотор орсон асуудал гэж үзээд хасаж өгнө үү.	<i>Холбогдох өөрчлөлтийг хийж тайланд тусгасан.</i>
4	Сонсох ажиллагааг 2021 оноос акт бүрд явуулж хэвшиж байна. 2019, 2020 оны хувьд сонсох ажиллагааг мөн явуулж ирсэн болно.	<i>Холбогдох өөрчлөлтийг хийж тайланд тусгасан.</i>
5	Тогтвортой амьжиргаа төсөлтэй хамтран ажиллах 2019 оны гэрээ баримтанд эх хувиараа байгаа, дээрх үйлдэл нь Төсвийн тухай хуулийн 47.1, 47.1.5-ын хүрээнд явуулсан үйл ажиллагаа юм.	<i>Төсвийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ тул тайлангаас хасаж шийдвэрлэлээ.</i>
6	2021 онд Ковидтой холбоотойгоор хөл хорио тогтоосон, хурал зөвлөгөөн хийхийг хориглосон, зарим бүс нутагт хөдөлгөөн хязгаарласан, төрийн байгууллага хяналт шалгалтаар ирээд өвчин тараалаа гэх эрсдэл бодитоор байсан зэрэг онц байдалтай холбогдуулан төрийн байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явагдах зарчмын хүрээнд баримт материалыг татан авч хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн. Дээрхи дүгнэлттэй санал нийлэхгүй байгаа тул хасаж өгнө үү.	<i>Ковид цар тахалтай хөл хорио тогтоосон үед хэрэгжүүлсэн арга хэмжээ тул тайлангаас хасаж шийдвэрлэлээ.</i>
7	2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг албан бичгээр хүргүүлсэн болно.	<i>Зөвлөмжийн биелэлт хангагдаагүй нь аудитын явцад тогтоогдсон тул тайланд засвар оруулах боломжгүй.</i>





**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 23

Ховд

**Гүйцэтгэлийн аудитын тайлан  
баталгаажуулах тухай**

Төрийн Аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 тоот тушаал, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга болон дотоод аудитын хороо, бусад шалгагдсан байгууллага, албан тушаалтанд хүргүүлсүгэй.

3. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэлийг статистик мэдээний маягтын нэгтгэлд бүртгэж, хэрэгжилтийг бүрэн хангуулан албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг тооцож ажиллахыг ахлах аудитор Д.Мөнхтулга, Л.Галбадрах, аудитор Ц.Аззаяа нарт, үр дүнг тооцон танилцуулахыг аудитын менежер /А.Цэцэгсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

